БАТЛАВ
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Г.ЧИНБАТ

2025 оны 06 сарын 02 өдөр

СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД АРДЫН ДУУ БҮЖГИЙН “АЛТАЙ” ЧУУЛГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Үндэсний түүх, өв соёлын онцлогийг агуулсан, мэдээлэлд суурилсан бүтээлч сэтгэлгээнд тулгуурласан бүтээлүүд бий болгох, соёл, урлагийн олон талт үйлчилгээг иргэдэд хүргэх, соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэхэд уран бүтээлийн байгууллагийн бүтээлийг чанаржуулах Соёлын салбар дахь ажил эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах үндсэн зорилготой .
2	Захиалагч	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар, АДБ-ийн Алтай чуулга
3	Ажил гүйцэтгэх хугацаа	2025.05.01-2025.07.15
4	Гүйцэтгэх ажлын хэмжээ	Шинэ уран бүтээл хийж байгаатай холбоотой шаардлагатай нэр төрлийн хувцас, малгай, бүс, гутал, тайз, жижиг хэрэглэлийг тоо ширхэгийн дагуу нийлүүлэх, хувцасны скез зургийг гаргаж батлуулан хүлээлгэн өгөх
5	Тавигдах шаардлага	Хийгдэж байгаа уран бүтээл нь шинээр дэглэгдсэн, найруулга хийгдсэн, шинээр бичигдсэн хөгжимтэй, шинэ хийгдсэн тайзтай байх
6	Ажлын хяналт, шалгалт	Уран бүтээл хийх баг хамт олон нь дээрх чиглэлээр ажил үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай байх
7	Гарах үр дүн	Шинэ уран бүтээлийн тоглолт хийснээр уран бүтээлчдийн уран чадвар сайжрахын зэрэгцээ, чуулгын урын санг баяжуулж, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тоглолтоор үйлчлэх боломжтой болно.
8	Ажлын гүйцэтгэл	Гэрээнд заасан хугацаанд шинэ уран бүтээлийг хийж дуусган хувцас, жижиг хэрэглэл, нот, партитур, скез зургийг байгууллагын Уран сайхны зөвлөлөөр хэлэлцэн урын санд хүлээлгэж өгөх
9	Санхүүжилт, эх үүсвэр	Аймаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 93,000,000 төгрөг

УРАН БҮТЭЭЛИЙН БАГТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

№	Хүний нөөц	Шаардлага
1	Продюссор	Энэ чиглэлээр урд өмнө нь төсөл хөтөлбөр дээр ажиллаж байсан. Удирдахуйн ухааны магистр, Соёл урлагийн менежер мэргэжилтэй. Удирдан зохион байгуулах, гэрээ хэлцэл хийх ажлын туршлагатай мэргэжлийн продюссор байх, Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цолтой.
2	Ерөнхий найруулагч	Мэргэжлийн Их дээд сургууль төгссөн. Найруулагч, бүжиг дэглээч мэргэжилтэй. Мэргэжлийн урлагийн байгууллагад 40-аас доошгүй жил ажилласан туршлагатай, бүжиг дэглээч, уран сайхны удирдагч, ерөнхий найруулагч, чуулгын дарга зэрэг албан тушаал хашиж байсан. Энэ чиглэлээр 100-аас доошгүй бүтээл туурвил бие даан найруулсан байх. Өөр бусад төсөл хөтөлбөр дээр ажиллаж байсан дадлага туршлагатай. Төрийн наадмын нээлт, Төрийн хүндэтгэлийн концерт зэрэг наадмуудыг найруулан дэглэн ажиллаж байсан туршлагатай. Соёл урлагийн салбарт олон нийтийн хүртээл болсон 10-аас доошгүй сод бүтээл туурвисан байх. Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Урагийн гавьяат зүтгэлтэн, доктор, профессор цолтой.
3	Хөгжмийн зохиолч	Хөгжмийн зохиолч, удирдаач чиглэлээр их дээд сургууль төгссөн. Мэргэжлийн уран бүтээлийн байгууллагад 30-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай. Өөрийн бие даасан дан болон найрал хөгжмийн концерт 30 гаруй, хөгжмийн 80-аас доошгүй бүтээлүүдтэй, Төрийн наадам болон бусад томоохон наадмуудын хөгжмийн зохиолчоор ажиллаж байсан туршлагатай. Соёл урлагийн салбарт олон нийтийн хүртээл болсон 8-аас доошгүй сод бүтээл туурвисан байх. Монгол Улсын хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, Урагийн гавьяат зүтгэлтэн, Морин хуур наадмын тэргүүн байрын шагналтай.
4	Хөгжмийн зохиолч, найруулагч	Үндэсний хөгжмийн застав бүрэлдэхүүнд хөгжим бичих, зохиох чадвартай, өөрийн гэсэн бичлэгийн студитэй байх, найруулга хийх чадвартай мэргэжлийн хөгжмийн зохиолч байх. Мэргэжлийн уран бүтээлийн байгууллагад 30-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай. Өөрийн бие даасан 40-өөс доошгүй бүтээлүүдтэй. Монгол Улсын хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, Хөдөлмөрийн хүндэт медаль болон төрийн дээд одон медалиар шагнагдсан байх.
5	Бүжгийн найруулагч, бүжиг дэглээч	Бүжгийн багш, дэглээчээр их дээд сургууль төгссөн. Мэргэжлийн урлагийн байгууллагад 20-оос доошгүй жил ажилласан. Энэ чиглэлээр 20-оос доошгүй бүтээл бүжиг дэглэсэн, 10-аас доошгүй бүжгийн бүрэн хэмжээний концерт найруулан тавьсан, Энэ чиглэлийн төсөл хөтөлбөр дээр ажиллаж байсан туршлагатай. Монгол Улсын хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас, Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.
6	Хормейстр	Мэргэжлийн их дээд сургуулийг Найрал дууны удирдаач мэргэжлээр төгссөн. Мэргэжлийн байгууллагад 20-оос доошгүй жил ажиллаж байсан дадлага туршлагатай. Дуучдын хоолойн бүрэлдэхүүнд найруулга хийх чадвартай байх. Өөрийн бие даасан 20-оос доошгүй

		бүтээлтэй. Монгол Улсын хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас, Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.
7	Зураач, дизайнер	Тайзны зураач чиглэлээр их дээд сургууль төгссөн. Хувцасны скез, дизайн зураг зурах чадвартай. Хувцас болон тайзны материалын сонголт хийх чадвар туршлагатай байх. Мэргэжлээрээ 30-аас доошгүй жил ажилласан туршлагатай. Хувийн урлантай. Төрийн наадам болон томоохон наадмуудын тайзны зураг, хувцасны скезийг гаргаж байсан туршлагатай. Гадны болон дотоодын загвар дизайны наадам уралдаануудад 5-аас доошгүй удаа оролцож амжилт гаргаж байсан.

ШИНЭ УРАН БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Бүжгийн бүтээлийн талаар

Төслийн хүрээнд дараах бүжгүүдийг шинээр хийж гүйцэтгүүлнэ.

- Сүлдэт цагаан шонхор
- Жангар-Ялалтын хийморь /Хүндэтгэл/
- Говийн зургаан гайхамшиг /багт/
- Говийн жонон /тойрон бүжиг/
- Шигшрэгт урианхай /Өөлд биелэгээ/

1.1 Шинээр хийгдэх бүжгийн бүтээл нь Говь-Алтай аймгийн онцлогийг харуулсан, /угсааны зүйн онцлог, хүрээлэн байгаа байгаль, орчин, газар зүй, ан амьтад, хүн зоны аж амьдрал/ байх бөгөөд дэглэлт, хувцас, хөгжим, тайз зэрэг нь шинээр хийгдсэн, мэргэжлийн уран бүтээлийн байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байвал зохино.

1.2 Бүжгийн хувцас, малгай, гутал, алчуур, бүс, нөмрөг, жижиг хэрэглэл зэрэг нь зураачийн гаргаж батлуулсан зураг скезийн дагуу тухайн бүжгийн бүтээлдээ тохирсон хэв загвартай байх ба материал, өнгө үзэмж сайтай, эдэлгээ даахуйц, эрэгтэй эмэгтэй төрөлтэй байх бөгөөд гэрээнд тусгасан тоо ширхэгийн дагуу шинэ уран бүтээлийн тоглолт хийгдэхээс өмнө үйлдвэрлэлээс гарсан байвал зохино.

1.3 Тухайн бүжгийн хөгжим нь Алтай чуулгын үндэсний хөгжмийн застав, бүрэлдэхүүнд тохирсон, дуучдын олон хоолойнд /хор/ бичигдсэн, орчин үеийн урсгал, чиглэлүүдийг зохих хэмжээнд тусгасан байвал зохино.

1.4 Тухайн уран бүтээлийн зохиогчийн эрхийг АДБ-ийн Алтай чуулгад хугацаагүйгээр эзэмшүүлнэ.

ШИНЭ УРАН БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

№	Хийгдэх ажил	Тоо, ширхэг	Хэмжих нэгж	Тавигдах шаардлага	Жишээ зураг
				1. Бүжгийн хувцас	
1.1	Дээл /эр-9, эм-9/	18	ш	Бүжгийн хувцас, малгай, гутал, алчуур, бүс, нөмрөг, жижиг хэрэглэл зэрэг нь зураачийн гаргаж батлуулсан зураг скезийн дагуу тухайн бүжгийн бүтээлдээ	

1.2	Малгай /эр-9, эм-9/	18	ш	тохирсон хэв загвартай байх ба материал, енге үзэмж сайтай, эдэлгээ даахуйц, эрэгтэй эмэгтэй төрөлтэй байх бөгөөд гэрээнд тусгасан тоо ширхэгийн дагуу шинэ уран бүтээлийн тоглолт хийгдэхээс өмнө үйлдвэрлэлээс гарсан байвал зохино.	
1.3	Гутал /эр-9, эм-9/	18	ш		
1.4	Бүс /эр-9, эм-9/	18	ш		

БОЛОВСРУУЛСАН

ЕРӨНХИЙ НАЙРУУЛАГЧ Б.ЖАРГАЛСАЙХАН